



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А1483

Улаанбаатар хот

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дугаар хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 18,207,545.00 (арван найман сая хоёр зуун долоон мянга таван зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ц.Цэрэндолгор)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 21 нэр төрлийн 18,207,545.00 (арван найман сая хоёр зуун долоон мянга таван зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Дотны туслагч” өрхийн эрүүл мэндийн төв (Ц.Цэрэндолгор)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 15... -ны өдрийн АИХ дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн Дотны туслагч ӨЭМТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ын мөргөжилт-ийн дүгнэлт	ҮХХХК-ийн шийтгэл
1	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	16	ш	1	1,360,000.00	1,360,000.00	1,360,000.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
2	Хөлийн массажны аппарат	16	ш	1	95,000.00	95,000.00	95,000.00	-	Эвдэрсэн	актлах	3,000	татах	татах
3	Хлостерин тодорхойлох аппарат	10	ш	1	300,000.00	300,000.00	300,000.00	-	Эвдэрсэн	актлах	2,000	татах	татах
4	Шээсний шинжилгээний аппарат	9	ш	1	1,700,000.00	1,700,000.00	1,700,000.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
5	DVD тоглуулагч	10	ш	1	140,600.00	140,600.00	140,600.00	-	Эвдэрсэн	актлах	3,000	татах	татах
6	Өнгөт принтер	10	ш	1	399,000.00	399,000.00	399,000.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
7	Бикс том	16	ш	1	19,500.00	19,500.00	19,500.00	-	Эвдэрсэн	актлах	500	татах	татах
8	Бикс жижиг	16	ш	1	15,500.00	15,500.00	15,500.00	-	Эвдэрсэн	актлах	500	татах	татах
9	Зөөврийн ЭХО аппарат	13	ш	1	5,550,050.00	5,550,050.00	5,550,050.00	-	Эвдэрсэн	актлах	20,000	татах	татах
10	Хөгжим	10	ш	1	256,405.00	256,405.00	256,405.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
11	Компьютерийн процессор	10	ш	2	1,550,000.00	3,100,000.00	3,100,000.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах
12	Ус буцалгагч	7	ш	1	85,000.00	85,000.00	85,000.00	-	Эвдэрсэн	актлах	2,000	татах	татах
13	Компьютерийн процессор	6	ш	1	1,275,000.00	1,275,000.00	1,275,000.00	-	Эвдэрсэн	актлах	5,000	татах	татах

